

**ӨМНӨД АФРИК: ТҮРЭМГИЙЛЭЛ,
ХАРГИСЛАЛ, МӨЛЖЛӨГ****Н. Дангаасүрэн**

Түүхийн ухааны доктор

Манай гаригийн хамгийн түгшүүрт хэсэгт өмнөд африк хамаарагдсаар олон жилийн нүүр үзэж байна. Түрэмгийлэл, харгислал, хэрцгий мөлжлөгөөр цууд гарсан голомтыг Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс (Өмнөд Африк) гэж албаны нэрээр хэлэлцдэг юм. Бодит байдалд энэ бол биеэ даасан бодлоготой, биеэ даасан үйл ажиллагаатай, олон улсын эрхийн хэм хэмжээг шударгаар сахигч, тусгаар тогтносон улс гүрэнтэй зүйрлэхийн аргагүй өөр шинж чанартай юм. Үүний гол шалтгаан нь уул орны төрийн эрх мэдэлд империализмын эрх ашгийг хамгаалагч, тэдний даалгаврыг биелүүлэгч тодорхой хүчин ноёрхож байгаад оршино. Иймээс өмнөд африкийн арьсны үзэлт дэглэмийг ганцаардмал үзэгдэ, санамсаргүй тохиолдол мэтээр үзэх нь зөвхөн өрнөдийн суртал нэвтрүүлгийн ов мэх төдий билээ. Олон улсын империализм бусад тив бүсэнд ноёрхолоо ямар ч үнээр гэсэн хадгалах үүний тулд юу ч хийхээс буцахгүйг Өмнөд Африкийн эрх баригчдын үйлдсээр буй балмад хэргээс хүн төрөлхтөн өдөр тутам үзэж байна. Империализмын бүрэн эрхшээлд оршиж, түүний эрх ашгийн хойноос улайран хөөцөлдөгч үүргээ, биеэ даасан төр улсын хэлбэр дүрсээр халхлагч энэхүү дэглэмийн үнэн байдал нь үгээр биш үйл хэргээрээ хэдийнээ батлагджээ. Үүнтэй холбогдуулан «бусад ард түмнийг дарлагч ард түмэн өөрсдөө эрх чөлөөтэй байж чадахгүй, өөр ард түмнийг дарлахад зориулагдсан тэр хүч нь эцсийн эцэст өөрсдийн нь эсрэг ямагт чиглэдэг»¹ гэсэн Ф. Энгельсийн мэргэн үгийг онцлон тэмдэглэмээр байна.

Өмнөд Африк, Израиль, Тайваний далдын дайнч эвслийг юуны урьд дурьдаж болно. Энэхүү гурамсан хуйвалдаан цөмийн түүхий эд-ураныг ашиглах ажлыг Өмнөд Африкийн нөөцөд түшиглэн өргөжүүлэхийн хамт цөмийн зэр зэвсгээр хөөцөлдөхөд голчлон чармайж байна. Холын тусгалт пуужин, алсын удирдлагаар нэн доогуур хэрэн нисдэг тийрэлтэт онгоц үйлдвэрлэх талаар тэд бас хамтран ажиллаж байгаа зэрэг цэрэг-дайны бэлтгэлийн түгшүүрт мэдээг НҮБ-ын удаа дараагийн албан баримтад тулгуурлан дурьдаж болох юм.² Өмнөд Африкийн зэвсгийн санд Израилиас орчин үеийн хэрэгсэл нийлүүлсээр байна. Израильд үйлдвэрлэсэн зэвсгүүд, түүний дотор ӨАБНУ-ын. далайн зэвсэгт хүчинд пуу- жинт усан хөлөг зургааг 1980 онд нийлүүлжээ. Ийнхүү израилиас Өмнөд Африкийг зэвсэглэл, зэвсэглэлийн үйлдвэр, мэргэжилтнээр хангаж байхад ӨАБНУ-аас Израильд цөмийн түлш, ган бусад чухал эрдэс багаж, төхөөрөмж нийлүүлж байна. Өмнөд Африк, Израиль, Тайваний эвслийн шинж чанар бол анхаарал татах хүчин зүйл юм. АНУ-ын толгойл-

1. К. Маркс, Ф. Энгельс, сочинения. М., 1961. т., 18 с. 509.

²Nuclear South Africa. "The Case for Sanctions Against South Africa", United Nations. New York, 1982. p. 34.

сон дэлхийн империалист хүчний зүгээс Ази, Африк, Латин Америкийн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дарахын тулд тэдгээр нутагт өөрсдийн хараат дэглэмүүдийг тогтоож бэхжүүлэх, тэдний хоорондын хуйвалдааныг өргөтгөх бодлогыг улам идэвхжүүлэх боллоо.

Олон улсын империалист хүчний шууд оролцоотойгоор Өмнөд Африкт төмөрлөг боловсруулах, суурь машин үйлдвэрлэл, электрон багаж үйлдвэрлэл, химийн үйлдвэр, зэрэг орчин үеийн чухал салбарууд, технологи зохион бүтээх чадамжтай эрдэм шинжилгээний томоохон төвүүд байгуулан өргөтгөж байна. Хөгжиж байгаа шинэ тулгар улс оронд байгуулж өгөхөөс шууд татгалздаг ийм салбарыг өрнөдийхөн ингэж харамгүй сэтгэлээр босгосон гэвэл үнэхээр гэнэн хэрэг юм. Энэ бол өрнөдийнхөн өөртөө өөрсдийн ноёрхлын тулд тэр тусмаа африкчуудыг төмөр чөдрөөр туших зорилготой байгуулжээ. Энэхүү хэт санаархалдаа Өмнөд Африкийн нутагт колоничлолын зорилгоор урьд суурьшуулсан цагаан арьстан хүн амдаа тулгуурлан тэдний тусгай улсыг байгуулж зэвсэглэн, чадалжуулах аргаар африкийн энэ хэсгээр барахгүй бүх африкийг ноёрхох түшиц газар болгохоор улам бүр хүчлэн оролдох болжээ. ӨАБНУ буюу энд өмнөд африк гэдэг товч нэрээр бичигдсэн орны төрийн мөн чанар, үүрэг чухам энэ юм.

Өмнөд Африкт атомын хэд хэдэн цахилгаан станц, атомын судалгаа, сургалтын төвүүд, цөмийн эрчим хүчийг дайны хэрэгцээнд шууд ашиглах илэрхий зориулалттай бусад салбар үйлдвэр зэрэг зэвсэглэл үйлдвэрлэх цогцолборыг хамгийн сүүлийн үеийн техник, технологийн түвшинд байгуулаад үргэлжлэн өргөтгөж байна. 1979 оны 9-р сарын 22-нд атлантын далайн өмнөд хэсэгт ӨАБНУ-ын хийсэн дэлбэлэлтийн сэжигтэй мэдээ түүнээс хойш гарсаар байгаа туршилт, сорилт, судалгааны ажлын мэдээ, сэлт нь дэлхийн улс түмэнд түгшүүрийн дохио өгч буй ноцтой баримт гэж манай ертөнцийн дэвшилт олон нийт үзэж байна. Өмнөд Африктай хуйвалдагч Израиль 1949 оноос цацраг идэвхт бодис судлах ажлыг идэвхжүүлж, негевын цөлөөс фосфорит олзворлон уран гаргах аргыг сүвэгчлэв. Одоо энэ чиглэлийн гурван үйлдвэр жил бүр 100 тонн орчим ураны хүдэр гаргаж байна. 60-аад онсос цөмийн физик, технологийн үндсэн салбарт судалгаа хийдэг эрдэм шинжилгээний хэд хэдэн төвтэй болжээ. Үүний хамт Өмнөд Африкаас уран авч буй мэдээ олонтой тохиолдож байна. НҮБ-ын баттай мэдээг иш татаж үзэхэд, Израиль өнөө үед 10-15 түүнээс илүү цөмийн цэнэгт хушуутай болсон байж болох юм.³ Бодит байдалд энэ бүхний гол хариуцлага нь АНУ, Өрнөд Европ, Японы империалистүүдэд ноогдох иш үндэстэй нотологоог НҮБ-ын албан баримт бичгүүд, дэлхийн олонхи улс гүрний төрийн болон засгийн дээд эрх барих газруудын албан ёсны мэдэгдлүүд, нам, олон нийтийн нэр хүндтэй байгууллагуудын гаргасан шаардлагуудад удаа, дараалан тусгагдсан байна. АНУ, Англи, Франц, Өрнөд Герман, Япон зэрэг⁴ нилээд орны техник, технологи, санхүү, мэргэжилтний шууд оролцоо тусалцаатайгаар, тэдгээр орны засгийн газруудын ивгээлээр, тэдгээр империалист гүрнүүдийн эзлэн түрэмгийлэх алсын ба өнөөгийн зорилгын дагуу Өмнөд Африк нэгэнт дээрмийн дайны зэвсэгийн сан болон хувирч байна. Эндээс африкийн 50 тусгаар тогтносон улсын эсрэг тэмцэж буй урван тэрслэгчдийг зэвсэглэж эндээс шинэ тулгар улсуудын энх тайван бүтээн байгуулалтыг саатуулах, хорлон сүйтгэх ажиллагааг хөлжүүлж байна.

³Study on Israeli Nuclear armament, n 6, United Nations, NY. 1982. p. 11, 15

4. Доклад международной конференции по санкциям против южной африки. Париж. 20—27 мая 1981 г. , ООН. с. 163.

К.Маркс заахдаа «Хэрэв шинжлэх ухааныг ухамсартай чиглүүлэхгүй урсгалаар хөгжүүлбэл эцэст нь цөл үлдэнэ»⁵ гэсэн юм. Тэр тусмаа өмнөд африкийн харгис дэглэмийг империалистүүд атом, цөмийн зэвсгээр зэвсэглэж буй нь хүн төрөлхтний хувь заяанд дэндүү осолтой явдал юм.

Бодит байдалд өмнөд африкийн дэглэм нь африкийн олон оронтой зарлагдаагүй дайны байдалтай оршиж, хэд хэдэн улс оронтой мөн чанартаа дайн хийж байна. Замби, Ботсван, Лесото зэрэг орны эсрэг улс төр, эдийн засаг, цэргийн шинжтэй дарамт шууд үзүүлсээр байна. Ангол, Зимбабве, Мозамбик, Танзани зэрэг орны эсрэг хорлон сүйтгэх, өдөөн хатгах, зэвсэгт мөргөлдөөн гаргах зэргээр үргэлжийн түгшүүрт байдлыг гааруулж байна. Түүгээр барахгүй зэвсэгт мөргөлдөөн тасралтгүй үргэлжлэх болжээ. Анголын өмнөд хэсгийн 50 мянган ам километр нутгийг өмнөд африкийн түрэмгийлэгчид зэвсгийн хүчээр булаан ноёрхсоор байна. Зэргэлдээ орнуудаас оргон зайлсан бүлгүүдийг энэхүү түрэмгийллээ халхлахад ашиглахаар барахгүй африкийн бусад тусгаар тогтносон улсуудад өөрийн талыг баримталсан дэглэмүүд бий болгох замаар империалист шинэ колоничлолын бүхэл системийг бүрэлдүүлэхээр империалист эздийхээ даалгавраар зогсоо зайгүй ажиллаж байна.

Африкийн шинэ тулгар тусгаар тогтносон орнуудын сэргэн-мандалт, биеэ даасан байдал, биеэ даасан сэтгэлгээ юунаас ч илүүгээр олон улсын империализмын дургүйцлийг хүргэжээ. Африкийн ард түмэн сургалтын системээ үндэснийхээ сэргэн мандалтанд үйлчлүүлэх болгосон ганц баримт ч гэсэн олон улсын харгис хүчнийг чичрүүлж буйг тэмдэг-лэхэд хангалттай юм. Зимбабвийн эрдэмтэн Нгавби Бхебе энэ талаар сонирхолтой санааг гаргасан⁶ байна. Тус орны сургуулиудад колоничлолын үед үзэж байсан сурах бичгүүдийн агуулгыг хэрхэн өөрчилснийг тэр дурьджээ. Империалистүүдийн зохиосон сурах бичгээр бол Африкт колоничлогчид хөл гишгэсэн тэр үеэс түүх эхэлж, тэднийг соён гийгүүлэгчид мэтээр магтан дэвэргэж, нөгөө талаар африкийн ард түмний түүх, үйлдвэрлэх хүчин, соёл, шинжлэх ухааны шилдэг уламжлалыг зэвүүцэн дарагдуулж байжээ. Харин чөлөөлөгдсөн Африкт энэ асуудал өөрөөр тавигдлаа.

Африкийн түүхийг африкийн ард түмний тэмцэл, тэдний хөдөлмөр, тэдний оюун санааны үр дүн гэж зүй ёсоор үзэж эхэлжээ. Чөлөөлөгдсөн Африкт үндэснийхээ эрх ашигт үйлдвэрлэх хүчин, соёл, шинжлэх ухааны ололтоо зориулж байхад чөлөөлөгдөөгүй Өмнөд Африкт тэр хүчийг уугуул ард түмний нь эсрэг, бүх Африкийн эсрэг чиглүүлжээ. Үндсээ чөлөөлөх явдлыг империализм ингэж үзэн ядаж байгаа болохоор нийгмээ чөлөөлөх тэрхүү дэвшилт үйлст хичнээн дайсагалтай хандах нь тодорхой юм. Ангол, Зимбабве, Мозамбик, Танзани зэрэг социализмыг баримжаалсан орны ард түмний эсрэг өмнөд африкийн эрх баригчдын дайн хийж буй явдлыг үүнтэй холбож үзэх нь зүй юм. Ямар учраас өмнөд африкийн зэвсэгт хүчин, оргодол бүлгүүдийн дэмжлэгийг давхар хэрэглэн зэргэлдээ шинэ тулгар орнуудын эсрэг түрэмгийлж байна вэ? гэдэг асуултанд Мозамбикийн ерөнхийлөгч саяхан хариулсныг энд дурьдахад хангалттай болно. Самора Машел үндэсний их хурал дээр тэмдэглэхдээ «Тэдний хил хязгаарын ойролцоо шинэ тусгаар тогтносон улс байгуулагдаж, шинэ, чөлөөт, шударга социалист нийгэм байгуулж, тэр нь энэхүү бүсийн бусад оронд дууриал үзүүлж байгаагаас айсандаа тэгж байна»⁷ гэжээ.

5. К. Маркс, Ф. Энгельс. Избранные письма. М., 1953. с. 202.

⁶“New York Times” 1982

7. «За рубежом» № 40, 1982.

Өмнөд Африкийн зэвсэгт хүчин Намибийг эзлээд нутгийн хүн амыг хэрцгийгээр дарлаж, байгалийн баялгийг цөлмөн хоосруулж байна. Баруун Өмнөд Африкийн ардын байгууллага (СВАПО) өргөн олны дэмжлэгт түшиглэн баатарлаг тэмцэл хийж байна. Намибийн ард түмний хууль ёсны цорын ганц байгууллага гэж НҮБ-ын шийдвэрт заагдсан эх оронч энэхүү хүч өдрөөс өдөрт өсч байгаа учир Өмнөд Африкаас Намиби дахь цагаан арьстан колоничлогчид, хөлсний этгээдүүдээр бүрэлдсэн бүлэглэлийг хичнээн дэмживч ахиц олохгүй болжээ. Намибийн ард түмний шударга тэмцлийг африкийн улс түмэн шийдвэртэй дэмжиж байна.

Империалистүүд, тэдний хөлсний зарц нар урьдах түүхэн сургамжаа эргэн санууштай юм. Ирээдүй бол чөлөөлөгдсөн Африкийн талд байна. Харин чөлөөлөгдөөгүй Африкийн талаар гэвэл тэдний өмнө ширүүн тэмцлээр тусгаар тогтнол, эрх чөлөөгөө олох бодит зам нээгджээ.

Өмнөд африкийн харгис дэглэм зөвхөн айл зэргэлдээ орнуудад уршиг тарьж байгаа төдий бишээ. Тэр орны дотоод байдал түүнээр номтой байна. ӨАБНУ-ын хүн амын бүрэлдүүнийг тэндхийн албан баримт бичигт голцуу арьс өнгөөр ялгаварлан гаргадаг, тэдний нийгмийн байр суурь яг үүгээр тодорхойлогддог байна. 1982 оны 3-р сард НҮБ-аас Өмнөд Африкийн талаар гаргасан товхимолыг энд үндэс болгож үзэхэд:⁸ Тус орны 30,7 сая хүний зөвхөн 4,4 сая нь цагаан арьстан европчууд юм. Хүн амын олонхи нь буюу 22,5 сая хар арьстан африкчууд Азийхан 880 мянга эд нар голдуу энэтхэг, пакистан гаралтай, бусад 3 сая нь холимог гаралтай болно.

Цагаан арьстан хэдийгээр үндэсний цөөнх нь боловч, нийт баялгийн ихэнхээр туйлж байдаг нь нийгмийн гүн гүнзгий шалтгаантай юм. Харийн түрэмгийлэгчид ба түүнд нэрвэгдсэн ард түмний эвлэршгүй зөрчил энд тусгагдаж байна. Империалистүүд, Африк тивийн энэхүү баялаг, таатай хэсэгт хүн амаа суурьшуулж тухлаад зогсохгүй, дангаар тэдний улсыг байгуулж байна. Тус орны нутаг дэвсгэрийн 85 хувийг цагаан арьстнууд эзэмшиж байна. Энэ бол хамгийн баялаг, амьдрахад илүү тохиромжтой хэсгийг шилэх арга замаар ялгагдсан нутаг юм.

ӨАБНУ-ын иргэний эрхийг цагаан арьстан биш гаралтай хүмүүст эдлүүлэхгүйн тулд ээлж дараатай арга хэмжээ авч байна. Колоничлогчдын мэдэлд мэдээж оршиж байдаг орчин үеийн аж үйлдвэр, хөдөө аж ахуй, шинжлэх ухаан, соёлын тохилог төвүүд, амралт үйлчилгээний газрууд, аль өөдтэй бүхнийг тэд эзэмшиж, тэдэнд зориулжээ. Энэ мэт ялгавар ч гэсэн колоничлогчдын ихэмсэг мөрөөдлийг хангасангүй. Уул нутгийн африк ард түмнийг энэ нутгаас нь хагацаан салгах бодлогыг эрээ цээргүй явуулж байна. Өмнөд Африкийн аль үржил шимгүй цутгийг товлон зааж африкчуудыг албадан бөөгнөрүүлж «хар улсууд» гэгчийг байгуулж байна. ӨАБНУ-ын нутаг дэвсгэрийн дөнгөж 13 хувийг эзэлсэн эдгээр «улсуудын» хооронд харилцан дайсагнуулах бодлогыг зориуд хурцатгаж байна. Транскей, Бопутасван, Венда, Сискей зэрэг тоглоомын «улсууд» нь мөн чанартаа африкийн ард түмний эсрэг шорон гяндны үүрэг гүйцэтгэж байна. Өөрийн эх нутагт харийн мэтээр гадуурхагдаж буй африкчуудын хүнд аж байдлыг өрнөдийн хэвлэл ч нууж чадахгүй бол- жээ. Транскей гэдэг «хар улсад» ажилладаг европын цөөн эмчийн нэгийн бичсэнийг «Стар» (Иоганнесбург) сонины хэвлэсэнд «Миний эмчилсэн хүмүүсийн эдгэрэхэд би юунд ингэлээ гэж гэмших юм. Надаар эмчлүүлж байгаа хүмүүс тэнхэл тамиргүй, өлөн байдлаараа залхаан цээрлүүлэхийн

⁸ Acrime against Humanity. United Nations, march 19826

хоригдлуудыг санагдуулдаг юм. Тэд эдгэрээд нөгөө уйтгар, өлсгөлөнгийн орондоо очно доо»⁹ гэжээ. Энэ бол жирийн эмч хүний энэрэнгүй сэтгэлийн илрэл юм. Харин империалист колоничлогчид энэ мэт үзэгдлийг огт өөрөөр үзэж байна. Африкчуудыг аль болохоор цөөрүүлэх явдал тэдний бодлогын үндсийн үндэс юм. Ливан, Сальвадор болж буй хэрэг явдал ч ийм л шинж чанартай байна. Энэ бүх балмад явдлын жинхэнэ эзэн нь нэг юм. Энэ бол олон улсын империализм мөн. 1,2 сая ам километр нутаг, түүний баялагийн хууль ёсны эзэн-Өмнөд Африкийн уугуул ард түмнийг империалистүүд, тэдний хөлсний зарц нар ингэж зэрлэгээр доромжилж байгааг түүх уучлахгүй. Хар арьстны авч буй цалин, хөлс цагаан арьстныхаас 5-10 дахин бага байна. Амьдрал, хангамжийн ялгавар өдөр шөнө шиг ялгаатай байгааг тоочивч баршгүй. Ийм байтал, өрнөдийн харгис суртал нэвтрүүлэг өмнөд африкийн «хар улсууд» бий болсон явдал бол африкчуудад эрх чөлөөг хязгааргүй хангасан, тусгаар тогтнох эрхийг хүртэл эдлүүлсэн мэтээр ичгүүргүй бичиж байна. Бодит байдал бол бүхнээс хүчтэй шалгуур юм. Африкийн ард түмэн хоосон үг, бодит байдал хоёрын ялгааг сайн мэдэх болж байна.

Өмнөд Африкт эзлэгдсэн Намибид харгислал бас ширүүсч байна. Өмнөд африкт харгисуудын өдүүлж буй бүх хэрэг явдал. Намибид давтагдаж байна. Намибийн нутгийн уур амьсгал, усны нөөц, үржил шим, эрдэс баялаг илүүтэй 43 хувийг колоничлогч-цагаан арьстны мэдэлд нэгэнт аваад үлдсэн хэсгийг цаашид булаан авахаар дараалсан бодлого явуулж байна. Ингэхлээр империализм, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бодлого нягт холбоотой, утга чанар нэгтэй оршиж байна. Империалистүүд Өмнөд Африк Намибид төдийгүй Африк даяар, бусад тивд энэ балмад бодлогыг хэрэгжүүлэхээр улайран оролдож байна. Ард түмнийг арьс, үндсээр ялгаварлах, «дээд», «доод» гэх мэтийн зэрэг дэв тогтоохыг оролдох явдал бол империализмын мөн чанарын тод томруун илрэл юм. Иймээс Өмнөд Африкийн ард түмний явуулж буй тэмцэл бол тэгш эрхийн төлөө Тэмцэл юм. Энэ хөдөлгөөн нь империализм, капитализмыг зэргээр эсэргүүцэж капитализмын өмнөх нийгмийн харилцааны үлдэгдлийг үндсээр халахад давхар чиглэсэн онцлогтой байна. «Өмнөд Африк бол колонийн нутаг дэвсгэр юм. Энэ учраас түүнээс чөлөөлөгдөх тэмцэл бол колоничлолын эсрэг тэмцэл мөн. Тэдний тэмцэл нь Ангол, Мозамбик, Зимбабвийн ам-жилттай өрнүүлж буй тэмцлээс ялгагдах зүйлгүй» гэж бүх африкийн их хурлын дарга ноён Ньяти Дж Покелын¹⁰ хэлсэн үг бодит байдлыг илэрхийлжээ. Өмнөд африкийн ард түмэн тэмцэлд босчээ. Тэд тэмцлийн бүх аргыг хэрэглэх дархан эрхтэй юм. Ийм Эрхтэй гэдгийг ч бүх дэвшилт хүн төрөлхтөн нэгэн дуугаар зөвшөөрч дэмжин талархаж байна.

Өмнөд Африк, мөн ойр тойронд хурцдаж буй мөргөлдөөний цаана юу нуугдаж байна? Яагаад хөгжингүй капитализм улс төрийн ийм тоглоом тоглож хөрөнгө, хүчээ хайрлахгүй байна? гэдэг асуулт зүй ёсоор тавигдана. В.И.Ленин: алив улс орны гадаад дотоод бодлогын «хамгийн гүн гүнзгий үндэс нь» тэрхүү улсын «эдийн засгийн сонирхол»¹¹ байдаг гэж олонтой тэмдэглэсэн байна. Энэ заалт олон улсын империализмээс өмнөд африкийн харгис дэглэмээр дамжуулан африкийн өмнөд хэсэг, нийт африкийн талаар тавьж буй бодлогын мөн чанарыг тодорхойлох

9. «За рубежом» № 38, 1982.

10. Доклад международной конференции по санкциям против южной африки, Париж. 20—27 мая 1981 г ООН с. 25.

11. В. И. Ленин. Полн. собр соч. т 36 с 337

чиг баримжаа болж байна. Капиталистууд нэг ч доллар дэмий гарздахыг төвдөхгүй атал өмнөд африкийн цэрэг-үйлдвэрийн цогцолбор, сэтгэл зүйн түрэмгийлэл, хорлон сүйтгэх, хутган үймүүлэх балмад хэрэгтээ дүнчүүрээр доллар шидэж байгаа учир бол Өмнөд Африк, Намибиас асар их ашиг хонжоо олдогт оршино.

Өмнөд африк бол олон улсын империализмын эрдэнэсийн томоохон сан хөмрөг болжээ. Энд манай гаригийн цагаан алтны төрөл металлын нөөцийн 80 хромитын 80, ванадийн 50, марганцын 50 хувь гэх мэтчилэн 54 зүйлийн ховор эрдэс, түүний дотор уран, сурьма, зэс чухал байр эзэлж байна. ӨАБНУ алт, алмаз, цагаан алт, марганц, хромит, ванади, сурьма боловсруулах талаар капиталист ертөнцөд нэгдүгээрт, вермикулит боловсруулалтаар хоёрдугаарт, ураны хүдэр цэвэршүүлэлтээр гуравдугаарт¹² орно. Эндээс жилд ураны цэвэршүүлсэн хүдэр 324 мянган тонныг гаргаж авч байгаа нь дэлхийн мөнхүү бүтээгдэхүүний 25 хувьтай тэнцэнэ. Өмнөд Африкт АНУ-ын 400 гаруй том компанийн салбарууд, 6 мянгаад фирм, Франц, Өрнөд Германы компанийн тус бүр 400 салбар, Английн компанийн 650 салбар гэх мэтчилэн тоочиж болох юм.¹³ Өмнөд Африк дангаар АНУ-ын жил тутмын хромын хэрэгцээний 48 хувь, цагаан алтны 82, марганцын 87, алтны 67, ванадийн 73 хувийг хангаж байна.¹⁴

Хөгжингүй капиталист гүрнүүдээс хөгжиж байгаа орнуудад жилд дунджаар 8 миллиард долларын «тусламж» гэгчийг шуугиан дэгдээж олгоод, түүгээр илүүдэл багаж, техникээ борлуулдаг нь улиг домог болсон юм. Ингээд тэрхүү «тусламжийн» хариуд жил тутам 25 миллиард долларын ашгийг чимээгүйхэн хүртэж байдгийг дашрамд дурьдаж болох юм. Намибиас гадаадад гаргаж байгаа зүйлийн 60 хувь нь эрдсийн түүхий эд байдаг. Далаад оны сүүлчийн байдлаар нэг жилд: чимэглэлийн алмаз 1,7 сая карат, мөнгө 42,5 тонн, зэс 28,2 мянган тонн хар тугалга 39.6 мянган тонн, Литий 6 мянган тонн, цагаан тугалга, 1,1 мянган тонн ванади 5 мянган тонн, цайр 48 мянган тонн байжээ. Намибийн нутагт нефтийн томоохон нөөц илрүүлсэн сүүлийн үеийн мэдээ империалист гүрнүүдийн шохоорхолыг улам татаж байна. Олон улсын империализмыг «хорьдугаар зууны дээрэмчид» гэж зарим хэвлэлд нэрлэснийг эрэгцүүлэн санахад тийм ч хилс үнэлэлт биш болов уу гэж боддог юм. Харин залруулж нэмэх зүйл гэвэл энэ дээрэмдлэг бүр 19-р зуунаас цааш, европын колоничлон эзлэлтээр эхэлсэн гэж хэлэх үндэстэй байна. Орчин, үеийн шинжлэх ухаан-техникийн ололт нь империалист гүрнүүдийн мөлжлөгийн хэмжээг ихээхэн нэмэгдүүлэх бололцоо олгож буй талыг тэмдэглэж болох юм.

Өмнөд Африк, Намибиас сорон авч буй эрдсийн баялагийн хэмжээ зогсолтгүй өсч байгаа нь нөгөө талаар эдгээр баялагийн барагдах хугацааг төчнөөн түргэн болгож байна. Намибийн алмазын нөөц 10-15 жилийн дараа дуусах төлөвтэй гэсэн судалгааны нилээд үндэстэй мэдээ болон Өмнөд Африк, Намибийн бусад эрдсийн нөөц ойрын 20-30 жилд эрс багасах төлөвтэйг урьдчилан харахыг өрнөдийнхөн огтхон ч сонирхоогүй дүр үзүүлдэг нь санамсаргүй зүйл биш юм. Өмнөд Африк, Намибийн ард түмний өөрсдийн эх орны бүрэн эрхт эзэн болох хугацааг хойш татаж, тэр завсар эрдэс баялагийг нь аль болох илүүтэй шавхан авахын тулд зэвсэгт хүчин, техник, эдийн засгийн бүхий л чадамжаа дайчлахыг империалистүүд чармайж байна. Үүний хамтаар африкийн шинэ тулгар тусгаар тогтносон улсуудад шинэ колоничлолын бодлого тулган хүлээл-

12. Анатолий Громыко. Конфликт на Юге Африки. М. , 1979. , с. 31

³ The Case for Sanctions Against South Africa, United Nations, New York, 1982, p. 25.

14. «Правда» 24. Ү. 1982.

гэх, Заир, Африкийн эвэр болон байгалийн баялаг нэн элбэг бусад бүс нутагт ноёрхлоо бэхжүүлэхэд өмнөд африкийн харгис дэглэмийг цаашид ч ашиглахыг зорьж байна. Африк тивд дэлхийн хромын нөөцийн 97 хувь, цагаан алтны 85, алтны 64, магнийн 50, ураны 25, зэсийн 13, **усан эрчим хүчний нөөцийн 20 тус тус оршин байгааг харгалзан үзэхгүйгээр** империалистүүдээс африкт явуулж буй бодлогын мөн чанарыг тодорхойлох аргагүй юм.

Олон улсын империализм орчин үеийн цэрэг-зэвсгийн хүчинд тулгуурлан Өмнөд Африк, Намибид колонийн жигшүүрт дэглэмээ өнөө болтол хэвээр хадгалж байгаа боловч африкийн ард түмний эсэргүүцэл, түрэлтийг удаан зогсоох чадал тэдэнд байхгүй. Өмнөд африк, Намибийн уугуул ард түмэн зэвсэг барин нэгэнт босчээ. Африкийн дэвшилт хүчин өдрөөс өдөрт өсөн бэхжиж байна. Энэ тэмцэлд дэлхийн шударга нааштай бүх хүчин нэгдэж байна. Өмнөд Африк, Намибийг чөлөөлөх тэмцэлд бодит социализм, түүний дотор БНМАУ идэвхтэй Дэмжлэг үзүүлсээр ирсэн одоо ч үзүүлж байна.

ЮЖНАЯ АФРИКА: АГРЕССИЯ, РЕАКЦИЯ И ЭКСПЛУАТАЦИЯ.

(Резюме)

В статье доктора исторических наук Н.Дангасурэна подчеркивается, что одной из опасных точек на нашей планете в течение многих лет остаётся Южно Африканская Республика, известная своей агрессией и реакцией.

В Южной Африке господствуют силы защищающие интересы империализма, стремящиеся усиленно проводить политику гонки вооружения, производств ядерного оружия.

В статье автор особое внимание уделяет сотрудничеству Южной Африки, Израиля и Тайвана в военной области, направленному на подавление национально-освободительных движений в странах Азии и Африки.

В стране развёрнуто широкое строительство комплексов военной промышленности атомных научно-исследовательских центров с целью использования ядерной энергии для военных нужд. Кроме того, режим в Южной Африке находится в состоянии необъявленной войны со многими африканскими государствами, оказывая на них давление в политическом, экономическом и военном отношениях.

Автор в статье приводит примеры героической, справедливой борьбы народной организации Юго-Западной Африки (СВАПО), народов Южной Африки за свободу и независимость своей страны, против империалистических и реакционных сил. Эта борьба находит поддержку во многих молодых независимых государствах Африки.

В погоне за большими прибылями и установление своего господства в этом регионе международный империализм проводит свою экспансионистскую политику через реакционнж режим Южной Африки. Однако, народы Африки и ее прогрессивные силы с оружием в руках встают на борьбу для защиты СЕОИХ законных прав. К этой справедливой, освободительной борьбе народов Южной Африки, Намибии и других африканских стран присоединяются все прогрессивные силы планеты.